



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН НЭР :БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Аудитын код: /ҮАГ-САГ/2017/10-ГА-БАГ-04

Дүгнэлт: Орон нутгийн татварын орлогыг 403,7 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 102,6 сая , төсөвт байгууллагын өөрийн орлогыг 283,1 сая нийт 789,4 сая төгрөгөөр давуулан биелүүлж , СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 985,6 сая төгрөгөөр тасалсан байна

Баянхонгор хот

2017 он

Тайланг бэлтгэсэн:

**Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх
аудитор**

Б.Мөнхбат

Аудитын менежер

.Цэцэгмаа

Ахлах аудитор

А.Цээням

Аудитор

М.Алтантуяа

2017 оны 4 дүгээр сарын 19

**Тайланг Аймгийн
аудитын газрын Цахим
хуудаснаас
үзнэ үү: www.audit.mn**

**Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70442584, 70442424
дугаарын утсаар
харилцана уу.**

**ХАЯГ: Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын
газар**

**Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-64000
Монгол Улс**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....3

Аудитын ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ.....4

АУДИТЫН ДҮН.....6

Нэг. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл.....6

Зорилт 1. 2016 онд татварын орлогын төлөвлөгөө 403,7 сая төгрөгөөр давж биелсэн боловч СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс аймгийн нийт орлогын төлөвлөгөө 196,2 сая төгрөгөөр тасарчээ.....6

1.1 Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар.....6

1.2 Гүйцэтгэлийн талаар.....9

Хоёр. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан.....12

Зорилт.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлээгүй ба ТЗШ-ийн байгууллагууд 720,8 сая, Орон нутгийн төсвийн байгууллагууд 140,5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.....12

2.1 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл:.....12

2.2 Орон нутгийн тусгай шилжүүлгийн талаар.....17

2.3 Тусгай сан.....18

2.4 Төсвийн шилжүүлэг.....21

2.5 Ангилалдаагүй зардал.....21

2.6 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансны талаар.....22

АУДИТЫН ДҮГНЭЛТ.....23

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвах
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХАХНХЯ	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл

1. Аудитын код: ҮАГ-САГ/2017/10-ГА-БАГ-04

Аудитын зорилт, хамарсан хүрээ : Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд :

- Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Үндэсний аудитын газраас ирүүлсэн төлөвлөгөөг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар дэд төлөвлөгөө хийж дараах зорилтыг хангах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд :

- Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт
- Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан
- Төсвийн гүйцэтгэлийн хавсралт судалгаа гаргах

4. Аудитын арга зүй : Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх , асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд : Үүнд :

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж

6. Аудит хийсэн хугацаа : Аудитыг 2017 оны 4-р сарын 15-наас эхэлж 4-р сарын 19-нд хийв.

7. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн : Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны ажлын хяналт тавьж, ахлах аудитор А.Цээням, аудитор М.Алтантуяа нар гүйцэтгэв.

АУДИТЫН ДҮН

Нэг. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Зорилт 1. 2016 онд татварын орлогын төлөвлөгөө 403,7 сая төгрөгөөр давж биелсэн боловч СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс аймгийн нийт орлогын төлөвлөгөө 196,2 сая төгрөгөөр тасарчээ.

1.1 Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар: УИХ-аас баталж, Сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2016 онд орон нутгийн орлогоор 5813,7 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2015.12.05-ны өдрийн хуралдааны 14/4 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 4501,5 сая, татварын бус орлогыг 507,1 сая, хөрөнгө борлуулсны орлогыг 466,3 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 715,5 сая төгрөгөөр буюу аймгийн дүнгээр нийт 6190,4 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь Сангийн яамнаас хуваарилан хянасанаас 376,7 тсая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд:

Татварын нэр төрөл	2015 СЯ-ны хянасан суурь	Аймаг, сумын ИТХ-ын анх баталсан дүн	Хүснэгт 01 /сая төгрөг/
			Зөрүү
Нийт орлогын дүн	5813.7	6190.4	376.7
Татварын орлогын дүн	5253.1	5125.4	-127.7
Орлогын албан татвар	3865.7	3990	124.3
Смчийн татвар	238.4	238.4	0
АТБӨЯХАТ	320	320	0
Бусад татвар /телбер хураамж/	829	577	-252
Татварын бус орлого	560.6	598.7	38.1
Хөрөнгө борлуулсны орлого		466.3	466.3

СЯ-наас хянасан 2016 оны суурь орлогын төлөвлөгөөг 376,7 сая төгрөгөөр нэмэгдүүлснийг нэр төрлөөр нь авч үзвэл Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварыг 124,3 сая, хөрөнгө борлуулсны орлогын татварыг 466,3 сая, татварын бус орлогыг 38,1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, хог тээврийн хураамжийн орлогыг 252,0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Сумдын санхүүгийн алба Төсвийн тухай хуулийн 66.1.4 “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх” гэсэн заалтын дагуу

сумын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг цаг хугацаанд нь бүрэн ирүүлээгүйгээс аймгийн ТЕЗ-чийн болон аймгийн Татварын хэлтсийн орлогын төлөвлөгөө зөрүүтэй мэдээлэгдэж, аудитын явцад хүндрэл учруулж байна.

Тухайлбал: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Татварын хэлтсийн төсвийн орлогын мэдээтэй тулган шалгахад 16 сум 8 төрлийн татварын орлогыг 568,5 сая төгрөгөөр нэмж сумын ИТХ-ын хуралдаанаар тодотгосон байхад аймгийн Татварын хэлтсийн татварын төлөвлөгөөний мэдээнд тодотгосон орлогын дүнг сумдын татварын байцаагч нар мэдээлээгүй байна.

Ан агнуурын татварын орлогын төлөвлөгөөг 13 сумд сумын ИТХ-ын хуралдаанаар нийтдээ 534,7 сая төгрөгөөр тодотгон баталсан байхад Аймгийн Татварын хэлтсийн ан агнуурын орлогын төлөвлөгөө 54,3 сая төгрөг буюу 480,2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, сумын Санхүүгийн албаны хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлан Төсвийн тухай хуулийн 8.9.4-д заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй тул цаашид хуульд заасан хугацаанд ирүүлэх талаар зөвлөмж өгөв.

Орон нутгийн орлогод орсон өөрчлөлт:

Тайлант онд аймгийн төсөвт нийт 3 удаа тодотгол хийж аймгийн ИТХ-ын хуралдаанаар нийт 1066.6 сая төгрөгөөр нэмэлт өөрчилөлт хийж, сүүлчийн тодотголоор орлогыг 6541,5 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.05.12-ны өдрийн 15/01 тоот тогтоолоор орон нутгийн зам ашигласны хураамжийн орлогыг 60,0 сая, хөрөнгө борлуулсны орлогыг 172,9 сая, Худалдан авах ажиллагааны албаны өөрийн орлогыг 9,1 сая төгрөгөөр буюу нийт 242,1 сая төгрөгөөр анхны батлагдсан орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлсэн
2. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.10.11-ний өдрийн ¾ тоот тогтоолоор Чандмань-Баянхонгор ХК-ийн уурын зуух, Баянлиг, Бууцагаан сумын төсвийн байгууллагуудын хуучин барилгуудыг дуудлага худалдаагаар борлуулах болсонтой холбогдуулан хөрөнгө борлуулах орлогыг 400,0 сая, зам ашигласны хураамжийн орлогыг 23,3 сая, ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого 215,3 сая, хандив

тусламжийн орлого 125,9 сая, нийт 764.5 сая төгрөгөөр өмнөх тодотгосон төсвийн орлогыг нэмэгдүүлсэн.

3. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ны өдрийн 4/3 тоот тогтоолоор хувь хүний орлогын албан татварыг 100,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ХХОАТ-ийн буцаан олголтыг 100.0 сая төгрөгөөр бууруулсан, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 200,0 сая, хүү торгуулийн орлогыг 50,0 сая, нийт 450,0 сая төгрөгийг нэмэгдүүлж, хөрөнгө борлуулсны орлогыг 390,0 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Сумд 2016 оны жилийн эцсийн төсвийн нэмэлт өөрчлөлтөөр татварын орлогыг 1141,7 сая, хүү торгуулийн орлогыг 103,5 сая, орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогыг 79,6 сая, Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 2336,9 сая, хандивын орлогыг 101,3 сая, нийт 3763,0 сая төгрөгөөр анхны батлагдсан төлөвлөгөөнөөс нэмэгдүүлэн баталжээ.

Аймгийн болон сумын ИТХ-ын хуралдааны дээрхи тогтоолуудаар орон нутгийн орлогод оруулсан тодотголоор аймгийн нийт орлогын төлөвлөгөө 10304,5 сая төгрөг болсон байна. Улсын төсвөөс 2016 онд орон нутгийн төсөвт 12317,4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 36416,4 сая, ОНХС-гаас 4737,8 сая төгрөгийг олгож, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогоор 103,4 сая, нийт 53575,0 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого авахаар баталсан байна. ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт орсон өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Үзүүлэлт	Аймгийн ИТХурлын тогтоол				Нийт тодотгосон төсөв
		2015.12.05-14/4	2016.05.12-15/1	2016.10.11-3/4	Дүн	
1	Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг	12,511.6	-	(194.2)	12,317.4	12,317.4
2	ОНХС орлогын шилжүүлэг	5,681.9	-	(944.1)	4,737.8	4,737.8
3	Тусгай зориулалтын шилжүүлэг	36,173.4	-	243.0	36,416.4	36,416.4
4	ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	65.2	36.7	1,5	103.4	103.4
	Нийт	54,432.16	36.68	(893.83)	53575.0	53575.0

Хүснэгт 02
/сая төгрөг/

1.2 Гүйцэтгэлийн талаар: Аймгийн дүнгээр 2016 онд орон нутгийн орлогоор анх 6190.4 сая төгрөг оруулахаар төлөвлөж, 4114.4 сая төгрөгөөр нэмж тодотгож, 10304.4 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 10108,2 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 196,2 сая төгрөгөөр тасарчээ.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 03
/сая төгрөг/

Д/Д	Орлогын төрөл		орон нутгийн жилийн эцсийн тайлангаар		Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	А.ОН Татварын нийт орлого		10,304.4	10,108.2	98%	(196.2)
	Үүнээс	татварын орлого	6,042.9	6,446.6	6.0	403.7
1	1. ХХОАТ		4,150.6	4,406.4	106%	255.8
		а.ЦХТАО /суутган-1/	4,500.0	4,763.1	106%	263.1
		Буцаан олголт	(780.0)	(802.3)	103%	(22.3)
		в.ИОТТХ	430.6	445.5	103%	14.9
		г.Патент			#DIV/0!	-
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар		180.0	186.9	104%	6.9
	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны		68.3	68.4	100%	0.1
3	3. Бууны татвар		52.9	38.0	72%	(14.9)
4	4.АТӨЯХАТ		320.0	359.8	112%	39.8
5	5. Бусад төлбөр хураамж		1,271.1	1,387.1	109%	116.0
	а.УТХ		180.1	213.0	118%	32.9
	б.Ашигт малтмалын нөөц ашигласны				#DIV/0!	-
	г.Түгээмэл тархацтай АМАТөлбөр		6.1	9.6	157%	3.5
	з.Ан, амьтан агнуурын нөөцийн		534.7	619.3	116%	84.5
	ж.Газрын төлбөр		130.0	107.5	83%	(22.5)
	й.Нохойны татвар		6.5	7.3	112%	0.8
	к. Ус ашигласны төлбөр		413.6	430.0	104%	16.4
	Хог хаягдлын хураамж			0.4	#DIV/0!	0.4
6	Хөрөнгийн орлого		649.2	751.8	116%	102.6
7	Хүү торгууль		622.1	644,2	104,0%	22,1
8	ТБӨО		2,763.0	1976,2	72%	(786,8)

9	Хандив	227.2	289.4	127%	62.2
---	--------	-------	-------	------	------

Дээрхи судалгаанаас харахад орон нутгийн нийт орлого дүнгээрээ 196,2 сая төгрөгөөр тасарсан боловч орон нутгийн татварын орлого давж биелсэн байна. Тухайлбал: Орон нутгийн татварын орлого 403,7 сая төгрөгөөр буюу 106,7хувиар, хүү торгуулийн орлого 22,1 сая буюу 104,0 хувиар давж биелсэн байна. Харин төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

1.2.1.Орон нутгийн татварын орлогын талаар: 2016 онд 6042,9 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 6446,6 сая, хүү торгуулийн орлогоор 622.1 мянган төгрөг оруулахаас 642,2 сая, хөрөнгийн орлогоор 649,2 сая төгрөг оруулахаас 751,8 сая төгрөг оруулж, харин бууны татвар 14.9 сая, газрын төлбөрийн орлого 22.5 сая төгрөгөөр тасарч, бусад нэр төрлийн орлого биелсэн байна.

График №1



Аймгийн Татварын хэлтсээс татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар судалгаа авч дүн шинжилгээ хийж давсан болон тасарсан орлогын шалтгааныг тодруулав. Үүнд:

Давсан орлогын талаар

- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого, АТБӨЯХАТ-ын төлөвлөгөө давсан нь сонгуульд ажилласан төрийн албан хаагчдын урамшууллын суутгалын

төлөвлөгдөөгүй орлого орсон болон аймгийн Цагдаагийн газар, Авто тээврийн үндэсний газрын харьяа Баянхонгор аймаг салбартай хамтран тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоо, татвар төлөлтийн байдалд байнга хяналт шалгалт хийж ажилласантай холбоотой байна.

- Тайлант онд ангийн зөвшөөрлийн хураамж 84,5 сая төгрөгөөр давсан нь шонхор шувуу барих зөвшөөрлийн хураамжийн орлого сумдад орсноос шалтгаалжээ.

- Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлогын гүйцэтгэлд шалаамнаас 359,6 сая, Бууцагаан, Баянлиг сумдын ашиглагдаагүй барилга болон бусад хөрөнгө борлуулсны 303,1 сая төгрөг орсноос орлогын төлөвлөгөө 102,6 сая төгрөгөөр давсан байна.

Тасарсан орлогын талаар

- Галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө тасарсан нь УИХ-аас 2016 онд баталсан “Галт зэвсгийн албан татварын тухай хууль”-иар галт зэвсгийн албан татварын хувь хэмжээг нэмэгдсэнээс шалтгаалжээ. Аймгийн Татварын хэлтэс, Аймгийн Засаг даргын 2016.11.04-ны өдрийн “Галт зэвсгийн албан татвар хураалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 04 тоот албан даалгавар гаргуулж бүртгэл, мэдээллийг шинэчлэн, холбогдох хууль тогтоомжийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж, татвар хураалтын ажлыг эрчимжүүлж ажилласны үр дүнд 18.7 сая төгрөгийн орлого оруулсан боловч бууны татвар 14,9 сая төгрөгөөр тасарсан.

- Газрын төлбөрийн орлого тасарсан нь Шинэжинст сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Гоби коулд энд энерги” ХХК нь 44.5 сая төгрөгийн ногдуулалтаас 22.5 сая төгрөгийг дутуу төлсөн, мөн бусад аж ахуйн нэгжүүд татвараа дутуу төлснөөс шалтгаалсан байна

1.2.2 Төсөвт байгууллагын өөрийн орлогын талаар:

Аймгийн дүнгээр төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2990,2 сая төгрөг оруулахаас 2265,6 сая төгрөг оруулж 724,7 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл						
						Хүснэгт 04
						/сая төгрөг/
Д/Д	Орлогын төрөл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тодотгосон төлөвлөгөөнөөс	хувь
	Төсөвт байгууллагын өөрийн орлого		2,990.2	2,265.6	(724.7)	75.8
1	Үүнээс	ОНТБ-ын өөрийн орлого	127.4	292.3	164.9	229.4
2		Орон нутгийн замашигласны хураамж	83.6	98.2	14.6	117.5
3		СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого	2,336.9	1,351.3	(985.6)	57.8
4		ОНХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс	215.0	234.4	19.4	109.0

2016 онд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 2336.9 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1351.3 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 985.6 сая төгрөгөөр тасарч энэ нь аймгийн нийт орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна. Энэ нь сумдын СХС-аас олгосон зээлийг хугацаанд нь төлүүлээгүй, зээл авсан иргэд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, сумдын Засаг дарга нар үүргээ биелүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Аудитаар төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн төлөвлөгөөтэй тулган шалгахад дараах зөрчил илэрлээ.

Баянлиг сумын ТЕЗ-ын ОНХС-ын төлөвлөгөөг сумын санхүүгийн албаны дарга аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнд 4,3 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгүүлсэн.

Хоёр. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан.

Зорилт.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлээгүй ба ТЗШ-ийн байгууллагууд 720,8 сая, Орон нутгийн төсвийн байгууллагууд 140,5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.1 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл:

2016 онд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаас төсөвт 3 удаа тодотгол хийж, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгээр 12317,4 сая, ОНХС-гийн шилжүүлгээр 4737,8 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 36416,4 сая төгрөг авах,

орон нутгийн төсвөөс 7314,6 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 4986,7 сая төгрөг, нийт 65772,9 сая төгрөгийг зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 12317,4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 36416,4 сая төгрөгийг авч, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4737,8 сая, орон нутгийн орлогоор 7842,6 сая, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 2265,6 сая төгрөгийн орлого оруулснаас төсөвт байгууллагуудын зардлын зарцуулаагүй үлдсэн харилцах дансны үлдэгдэл 861,3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, 61948,7 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,772.87	61,948.74	3,824.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,247.28	60,015.94	2,231.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,822.55	45,736.51	1,086.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,049.97	28,638.68	411.29
210101	Үндсэн цалин	24,350.25	24,162.84	187.41
210102	Нэмэгдэл	2,112.90	2,030.78	82.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66.41	68.96	(2.55)
210104	Урамшуулал	1,476.03	1,360.04	115.99
210105	Гэрээт ажлын хөлс	1,044.37	1,016.06	28.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,227.90	3,147.99	79.91
210201	Тэтгэврийн даатгал	3,227.90	3,147.99	79.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,727.42	4,627.41	100.01
210301	Гэрэл, цахилгаан	435.96	432.31	3.64
210302	Түлш, халаалт	3,939.54	3,884.18	55.36
210303	Цэвэр, бохир ус	290.79	249.78	41.01

210304	Байрны түрээс	61.14	61.14	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,206.96	1,194.78	12.18
210401	Бичиг хэрэг	147.92	156.36	(8.44)
210402	Тээвэр, шатахуун	716.93	705.36	11.56
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	182.69	163.45	19.24
210404	Ном, хэвлэл	38.81	40.06	(1.26)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26.71	27.74	(1.03)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	93.90	101.80	(7.90)
2105	Нормативт зардал	2,901.30	2,750.30	151.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	267.28	265.84	1.44
210502	Хоол, хүнс	2,513.88	2,364.79	149.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120.14	119.67	0.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	567.93	554.65	13.28
210601	Багаж, техник, хэрэгсэл	38.90	38.19	0.71
210602	Тавилга	131.99	131.79	0.21
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.84	0.60	0.24
210604	Урсгал засвар	396.20	384.07	12.13
2107	Томилолт, зочны зардал	233.01	226.12	6.89
210702	Дотоод албан томилолт	233.01	226.12	6.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,518.54	1,187.36	331.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,466.33	1,139.35	326.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7.97	7.47	0.49
210803	Даатгалын үйлчилгээ	13.82	13.31	0.51
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4.59	4.42	0.17
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1.21	1.10	0.12
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16.50	14.92	1.58
210807	Газрын төлбөр	1.98	1.70	0.28

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5.46	4.43	1.03
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.67	0.66	0.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3788.92	3,409.22	(19.70)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3693.14	3,330.99	(37.25)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	95.78	78.23	17.55
212	ТАТААС	26,0	26.00	399.39
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	26,0	26.00	399.39
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	425.39	26.00	399.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,999.34	14,253.43	745.91
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,003.84	4,660.41	343.43
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,003.84	4,660.41	343.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,995.50	9,593.02	402.48
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,096.46	1,096.46	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,592.39	6,247.87	344.52
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	87.69	78.92	8.78
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	781.59	761.14	20.45
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	971.27	946.11	25.16
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	355.38	353.87	1.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110.72	108.65	2.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,958.98	1,321.06	637.92
2200	Дотоод эх үүсвэрээр	1,958.98	1,321.06	637.92
220001	Барилга байгууламж	-	20.14	(20.14)
223001	Бусад хөрөнгө	1,958.98	1,300.91	658.07
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,566.60	611.74	954.87
230001	Эргэж төлөгдөх зээл	1,566.60	611.74	954.87
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,772.87	62,718.37	3,054.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,416.40	35,695.54	720.87

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	36,416.40	35,695.54	720.87
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,369.76	24,757.27	(387.51)
132001	Орон нутгийн төсвөөс	19,631.94	20,019.45	(387.51)
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	4,737.82	4,737.82	(0.00)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,986.71	2,265.56	2,721.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,404.94	1,786.20	618.74
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	688.29	479.36	208.93
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,893.48	-	1,893.48
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	808.43	(808.43)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,578.06	(1,578.06)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	210.00	210.00	-
610001	Төсвийн байгууллага	206.00	206.00	-
610002	Төсвөөс гадуур байгууллага	4.00	4.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,649.00	3,663.00	(14.00)
620001	Удирдах ажилтан	328.00	266.00	62.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2,099.00	2,242.00	(143.00)
620003	Үйлчлэх ажилтан	892.00	833.00	59.00
620004	Гэрээт ажилтан	330.00	322.00	8.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	20,408.00	21,496.00	(1,088.00)
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	15,897.00	16,276.00	(379.00)
630001	Төрийн өмчит ЕБС	15,897.00	16,276.00	(379.00)
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	4,511.00	5,220.00	(709.00)
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	4,511.00	4,784.00	(273.00)
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага		436.00	(436.00)
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	16,379.50	(16,379.50)
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо		3,355.50	(3,355.50)
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо		13,024.00	(13,024.00)
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,649.00	3,663.00	(14.00)

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	366.00	321.00	45.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3.00	-	3.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	1,445.00	1,426.00	19.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	152.00	148.00	4.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		82.00	(82.00)
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		270.00	(270.00)
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,185.00	918.00	267.00
650010	Гэрээт ажилтан	330.00	331.00	(1.00)
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	168.00	167.00	1.00

Энэ нь урсгал үйл ажиллагааны зардлыг 2869,2 сая төгрөгөөр хэмнэж, СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтийг 954,8 сая төгрөгөөр санд дутуу оруулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бараа ажил үйлчилгээний урсгал зардлыг нэр төрлөөр авч үзвэл цалин хөлс, НДШ-ийн зардлыг 491,2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 100,0 сая төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 149,0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн орлогыг 326,0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 379,7 сая төгрөгөөр, нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 344,5 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийг 343,1 сая төгрөгөөр, бусад зардлыг 96,9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ хэмнэлт нь дээрх төсөвт зардлыг гүйцэтгэлд нь хяналт тавьж санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

2.2 Орон нутгийн тусгай шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр

- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Үүний дагуу ЭМСС, ХАХНХС,БХБС,БСШУС-ын төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийн 36416,3 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутагт байршилтай байгууллагуудад Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу олгож оны эцэст харилцах дансны үлдэгдэл 720,8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Харин БСШУС-ын сайдын 2016.12.08-ны өдрийн 1а/4099 тоот албан бичгийг үндэслэн аймгийн Засаг дарга 2016.12.15-ны а/792 тоот захирамжаар Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-ийн “г”, 42.2.2 дахь хэсгийг үндэслэн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв хооронд зохицуулалт хийсэн ба мөн Ерөнхий боловсролын сургуулийн багцын санхүүжилтээс 27.8 сая төгрөгийг Соёлын байгууллагуудын санхүүжилтэд олгосон байна.

2016 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:			
		БСШУС-ын сайд	ХАХНХ-ын сайд	ЭМС-ын сайд	БХБ-ын сайд
Батлагдсан төсөв	36,416.4	30,703.1	109.9	5,368.0	235.4
Олгосон урсгал санхүүжилт	36,416.4	30,703.1	109.9	5,368.0	235.4
Нийт төвлөрүүлсэн	720.8	681.9	0.0	32.0	6.9
Үүнээс:Төсөвт /СЯ/	720.8	681.9	0.0	32.0	6.9

2.3 Тусгай сан

2.3.1 Замын сан: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016.04.04-ны 25 тоот тогтоолоор анх 2015 оны шилжих үлдэгдлээс 5 арга хэмжээнд 21,5 сая, шинээр эхлэх 15 төсөл, арга хэмжээнд 320,0 сая батласан ба аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 43, 47, 89, 97 тоот тогтоолуудаар тодотгон 29 төсөл, арга хэмжээнд нийт 490,2 сая төгрөг зарцуулахаар баталсан байна. 2016 онд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоор 320,0 сая төгрөг оруулахаар төлөвлөж

359,8 сая төгрөг орж, орлогын төлөвлөгөөг 39,8 сая буюу 112,4 хувиар биелүүлсэн байна.



Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 142,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба АТБӨЯХАТ-ын орлогоос санхүүжилтээр 262,0 сая, авто зам ашигласны хураамжийн орлогоор 98,2 сая төгрөг орж, нийт 360,2 сая төгрөгийн орлого төвлөрсөнөөс 28 батлагдсан төсөл, арга хэмжээнд 481,5 сая төгрөгийн зардал гаргаж, оны эцэст 21,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.3.2 Орон нутгийн хөгжлийн сан: 2016 онд тус аймагт ОНХНС-гаас 5681,9 сая төгрөг хуваарилсныг аймгийн ИТХ-ын 2015.12.05-ны өдрийн хуралдааны 14/4 тоот тогтоолоор баталсан ба Улсын нэгдсэн төсөвт тодотгол хийсэнтэй уялдуулан аймгийн ИТХ-ын 2016.10.11-ны өдрийн хуралдааны 3/4 тоот тогтоолоор 4737,8 сая төгрөгөөр тодотгон 944,1 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

2016 онд улсын төсвөөс аймгийн ОНХНС-нд 4737,8 сая төгрөгийн санхүүжилт олгосоныг аймгийн ОНХС-д 1895,1 сая, сумын ОНХС-д 60,0 хувь буюу 2842,7 сая төгрөгийг олгосон байна.

2016 онд эхэнд ОНХС нь аймгийн нэгдсэн дүнгээр 433,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба ОНХНСангаас 4737,8 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 132,9 сая, хандив, тусламж бусад орлогоор 1195.7 сая төгрөг орж, нийт 5607.5 сая төгрөгийг төсөл, арга хэмжээ бусад зардалд зарцуулан оны эцэст 892.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Үүнээс санд орсон орлогыг тодруулвал сангаас олгосон зээлийн эргэн төлөлтөөс 234,3 сая, уул уурхайн компаниудаас 144,0 сая төгрөгийн хандив, шламны орлогоос 359,6 сая, бусад орлогоор 449,3 сая төгрөг дансанд төвлөрсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар сангаас төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгож ажлыг хүлээн аваагүй, сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлыг санхүүгийн тайланд дутуу тусгасан зэрэг зөрчил илэрсэн байна.Тухайлбал:

- Баянговь сум ОНХС-ийн хөрөнгөөр шилэн хорго хийлгэхээр иргэн Ш.Болдбаатарт 1.5 сая төгрөг олгоод ажлыг хүлээн аваагүй.
- Жаргалант сум "Ургахам" ХХК-д 10.0 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй.
- Баянхонгор аймгийн ОНХС-д үйл ажиллагааны орлогоор орсон 20.2 сая төгрөгийг санхүүгийн тайланд дутуу илэрхийлж, авлагыг 8.7 сая төгрөгөөр дутуу тусгасан.

- Богд сум "Алтанзавьяа ундарга" ХХК-д Богд сумын 0.4 квт-ын цахилгааны дамжуулах шугамын өргөтгөлийн ажлын 0.6 сая төгрөгийн хяналтын зардлыг суутган тооцолгүй гүйцэтгэгч байгууллагад олгосон.
- Гурванбулаг сум ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Жи мобайлын сүлжээнд холбогдох" ажлын 45.8 сая, "4-р багийн төвийн гаднах хайсын тохижилт"-ын ажлын 2.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон атлаа ажлыг гүйцэтгүүлэн хүлээж аваагүй, мөн тайланд 39.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.
- Хүрээмарал сум ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Цорж 4-р багт аялал жуулчлалын тоног төхөөрөмж авах " арга хэмжээний 10.0 сая төгрөг, "Нийтийн биеийн тамирын талбайтай болох " арга хэмжээний 9.4 сая төгрөгийн гэрээний хугацаа дууссан, санхүүжилтийг бүрэн авсан атлаа гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байна.

2.3.4 Сум хөгжүүлэх сан:

Баянхонгор аймгийн 20 сумын Сум хөгжүүлэх сангийн дансанд 2016 оны эхэнд 237,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоос 1337,7 сая, бусад эх үүсвэрээс 13,5 сая төгрөгийн орлого орсноос 855,9 сая төгрөгийг зээлд олгож, үйл ажиллагааны зардалд 18,7 сая, бусад зардалд 55,1 сая төгрөг зарцуулан оны эцэст 658,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2016 оны эцсийн байдлаар санхүүгийн нэгтгэсэн тайланд СХС-гаас хувь хүмүүст олгосон зээлийн 4104,6 сая төгрөгийн авлагатай байна.

Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зээлийн хүү, зээлийн авлагыг тайланд зөрүүтэй тусгасан, сангаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Богд сум зээлийн авлагыг санхүүгийн тайланд 1.6 сая дутуу, сумын Засаг даргын 2016.07.27-ний өдрийн А/93 тоот захирамжаар өвс тэжээлийн нөөц бэлтгэх гэрээг "Нэгэн хамт олон", "Мөнх таван богд" малчдын холбоо ТББ-уудтай хийн 5.8 сая төгрөг шилжүүлсэн ч ажлаа гүйцэтгээгүй.
- Баянхонгор сум 2016 онд олгосон зээлийн хүүг зөрүүтэй тооцоолсноос 4.8 сая төгрөгийг дутуу бүртгэгдсэн.
- Баянговь сум зээлийн авлага 2,6 сая төгрөгийг дутуу илэрхийлсэн
- Баянлиг сум ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжөөс 8.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Галуут сум авлагыг 33,8 сая төгрөгөөр дутуу тусгасан.
- Баянбулаг сум зээлдэгч нарын авлагыг тайланд 84.8 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

- Гурванбулаг сумын СХС-гаас олгосон зээлээс гэрээний хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс 7.8 сая, Хүрээмарал сум 9.5 сая төгрөгийг барагдуулаагүй байна.

2.4 Төсвийн шилжүүлэг

❖ **Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж:** Нийгмийн халамжийн сангаас 8 төрлийн тэтгэвэр, тэтгэмжид 7688.9 сая, үйл ажиллагааны зардалд 55.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс тэтгэвэр тэтгэмжид 7344.1 сая, үйл ажиллагааны зардалд 55.9 сая төгрөг зарцуулж нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлснээс 344.8 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

❖ **Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал:** Үдийн цай хөтөлбөрт 781,6 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 761,1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 20,4 сая төгрөгөөр хэмнэсэн нь хүүхэд өдрийн гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

❖ **Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж:** тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 971,3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 946,1 сая төгрөгийн тэтгэмжийг олгож 25,1 сая төгрөгийг хэмнэжээ.

❖ **Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг:** 2016 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг олгоход 355,4 сая төгрөг баталснаас, 353,9 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

2.5 Ангилалдаагүй зардал

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2015.12.05-ны өдрийн 14/4 тоот тогтоолоор ангилагдаагүй зардалд 17 хөтөлбөр арга хэмжээнд 963.9 сая төгрөг баталсан, 2016.10.11-ний өдрийн 3/04 тоот тогтоолоор 478.4 сая төгрөг, 2016.12.02-ны өдрийн 4/3 тоот тогтоолоор 85.6 сая төгрөгийг тус тус нэмж тодотгон нийт 1527.9 сая төгрөгийг 30 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1517.8 сая төгрөг зарцуулжээ.

Ангилалдаагүй зардлаас санхүүжүүлэхээр баталсан 28 төслөөс гудамж хариуцсан идэвхтэний зардал 6.1 сая, шинэ зууны эмч 6.8 сая, спортод амжилт гаргасан тамирчдыг дэмжих хөтөлбөр 2.2 сая, үндсэн чиглэлийн ном хэвлүүлэх зардал 1.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн ба 2016.08.04-ний өдрийн А/520 тоот аймгийн Засаг даргын “Төсөвт зохицуулалт хийх тухай” захирамжаар аймаг, сумдын

ЗДТГ-ын автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэхэд 1.7 сая төгрөгийг нэмж зарцуулсан байна.

Тухайн дансаар ахмадын байгууллагын санхүүжилтийн 81.2 сая төгрөгийн гүйлгээ дамжсан бөгөөд дансны нэр зөрүүтэйгээс буцсан 279.0 сая төгрөгийн гүйлгээ гарч оны эцэст зарцуулаагүй үлдэгдлийн 10.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Ангилагдаагүй зардлаас санхүүжигдсэн татварын буцаан олголтын 286.9 сая төгрөгийг аймгийн ерөнхий орлогын данснаас шууд шилжүүлсэн байна.

2.6 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансны талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн нэмэлт санхүүжилтын дансаар 1875,4 сая төгрөгийн орлого орж 53,6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 1821,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитаар нийт 572,8 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. 2016 онд орон нутгийн нийт орлогын төлөвлөгөөг аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар 4114,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 10304,4 сая төгрөгөөр баталж, 10108,2 сая төгрөгийн орлого оржээ.
2. Орон нутгийн татварын орлогыг 403,7 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 102,6 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 283,1 сая нийт 789,4 сая төгрөгөөр давуулан биелүүлж, СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 985,6 сая төгрөгөөр тасалсан байна.
3. Сумдын санхүүгийн алба Төсвийн тухай хуулийн 66.1.4 "иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх" гэсэн заалтын дагуу сумын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг цаг хугацаанд нь бүрэн ирүүлээгүйгээс 16 сум 8 төрлийн татварын орлогыг 568,5 сая төгрөгөөр нэмж сумын ИТХ-ын хуралдаанаар тодотгосон байхад аймгийн Татварын хэлтсийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй байна.
4. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулаагүй ба ТЗШ-ийн байгууллагууд 720,8 сая, Орон нутгийн төсвийн байгууллагууд 140,5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал,
аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
С.Байгалмаа нар танаа

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

1. Орон нутгийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 21.2 дахь заалтын дагуу сумын суурь орлого болон суурь зарлагыг оруулсан дүнгээр баталж байх.
2. Аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс сумдын санхүүгийн албанаас төсөв баталсан, тодотгосон шийдвэрийг тухай бүр нь авч, орлого, зарлагын төлөвлөгөөний нэгтгэлийг хийх, жилийн эцэст төсвийн мэргэжилтэнтэй тодотгосон төсвийн хуваарийг байгууллага бүрээр нийлж, улсын төсөв болон орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийг тулган баталгаажуулж байх, Төсвийн тухай хуулийн 66.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2012.11.19-ны өдрийн 244 тоот тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.
3. Авто замын сангийн хөрөнгийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 67.1."Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ." гэсэн заалтын дагуу төсөл, арга хэмжээ нэг бүрээр төлөвлөгөө боловсруулан аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулж, сангийн хөрөнгөөр хийсэн төсөл арга, хэмжээг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх.
4. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн мэргэжилтэн, Аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжил нар төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд шинжилгээ хийж төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, төсөвт зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны талаар тайлбар тодруулга гаргаж байх. Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2017 оны 6 дугаар сарын 20-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

22

